



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Албан томилолтоор ажиллуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан томилолтоор ажиллуулах журам"-ын 2.1, 3.1, 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Саранцэцэгийг Орхон аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй 2202000010002 дугаартай Т.Батмөнх, Д.Болортуяа нарт холбогдох шүүх хуралд хохирогч, иргэний нэхэмжлэгчээр оролцох зорилгоор орон нутагт зорчих удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан томилолтын тайланг ажлын 5 өдөрт багтаан танилцуулахыг Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн /Ө.Саранцэцэг/-т даалгасугай.

3.Албан хаагчийн унаа, томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

130013675

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний
өдрийн 1/20 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



ОРХОН АЙМАГТ ТОМИЛОЛТООР
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Зорилго: Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй 2202000010002 дугаартай Т.Батмөнх, Д.Болортуяа нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралд хохирогч, иргэний нэхэмжлэгчээр байгууллагын эрх ашиг хамгаалан оролцох

Хугацаа: 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд;

Хаана: Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шат шүүх

Гүйцэтгэх ажлын хуваарь:

Д/д	Гүйцэтгэх ажил	Хугацаа	Гүйцэтгэх мэргэжилтэн
1	2202000010002 дугаартай Т.Батмөнх, Д.Болортуяа нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралд байгууллагын эрх ашиг хамгаалан оролцоно.	2023.09.13- 2023.09.15	Ө.Саранцэцэг

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
даргын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн
4/30 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхэд хянагдаж буй 2202000010002 дугаартай Т.Батмөнх, Д.Болортуяа нарт холбогдох эрүүгийн хэргийн шүүх хуралд оролцох албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ө.Саранцэцэг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд /хуанлийн 3 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	2	3
1	Байр: 1 хүн 3 хоног х 110,000 =330,000 Хоол: 1хүн 3 хоног х 32,000 = 96,000 Унаа: 760 км х 2390 х 0.25 х = 454,100	880,100
	Нийт дүн:	

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэв.

----- о 0 о-----